



Military Service Legislation in the Yuan Dynasty

Togtuun Erdenekhishig

Ph.D., Professor, Leading Research Fellow, Center for Military History Studies, Defense Research of Mongolia, E-mail: khishig_39@yahoo.com, ORCID: [0009-0007-2972-954X](https://orcid.org/0009-0007-2972-954X)

Received: 15 June 2026

Revised: 24 June 2026

Accepted: 28 June 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

Military service regulations during the Yuan Dynasty formed an important part of the empire's legal system and were incorporated into the broader framework of state law. The Yuan military organization inherited the decimal system that had characterized the political and military institutions of the Mongols during the early and medieval periods. At the same time, it was further developed in conjunction with the administrative structure, household registration system, and taxation mechanisms of the sedentary Chinese state. According to Yuan legislation, military conscription among the Mongol population was organized on a household basis. The law stipulated that households with two or three male members were required to provide one soldier; those with four or five male members two soldiers, and those with six or seven male members three soldiers. This regulation served as the principal legal basis for recruiting soldiers from Mongol households. In addition, military recruitment and replenishment within the Chinese territories of the Yuan Empire were carried out through the institution of military households. Military households consisted of Mongol families resettled in China as well as the families of soldiers from the former Jin and Song states who had surrendered to the Mongols.

The legal obligations associated with military service were well understood among households that had performed military duties over several generations. Yuan legislation explicitly stipulated that military service must be performed in person and that those who resisted or evaded service would be subject to punishment. In cases where individuals fled due to poverty, responsible officials were required to investigate the circumstances thoroughly. If poverty was found to have been falsely claimed as a pretext for evading military obligations, supervisory authorities were authorized to conduct further investigations.

During the Yuan period, separate registers were maintained for military households, tamachi troops (military units established by the Mongols and stationed in conquered territories), Chinese troops, and substitute military households. Conscription policies were implemented on the basis of each household's economic condition, labor capacity, and ability to fulfill military obligations. In particular, the system of regular and substitute military households was designed to ensure the continuity of military service and to prevent shortages of military personnel. Military service was hereditary in nature, and the obligation could be transferred not only to male members of the household but also to sons-in-law and other relatives. This legal arrangement demonstrates the importance that the Yuan state attached to maintaining the stability and continuity of military households. The military law of the Yuan Dynasty regulated not only conscription and military service but also military discipline, military offenses, wartime regulations, and relations between military personnel and civilians.

Keywords: The Yuan Dynasty, Military service legislation, Incentive, Punishments, Benefits, Household Registration System

Юань улсын цэргийн албаны хууль

Тогтуун Эрдэнэхишиг

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор (Ph.D), профессор
khishig_39@yahoo.com, ORCID: 0009-0007-2972-954X

ХУРААНГУЙ

Юань улсын үеийн цэргийн албаны хууль нь цэргийн хуулиндаа багтаж, цэргийн албаны хууль нь бусад хуулиндаа багтдаг байсан байна. Юань улсын цэргийн байгуулал нь аравтын тогтолцоонд суурилсан монголын эрт, дундад үеийн төр, цэргийн зохион байгуулалтыг уламжлан авахдаа хятадын суурин иргэнийн төрийн захиргаа, хүн амын бүртгэл, татварын тогтолцоотой уялдуулан хөгжүүлсэн юм.

Эрчүүдийг цэргийн албанд татахдаа “Өрх бүр 2-3 эртэй бол нэг хүн, 4-5 эртэй бол 2 хүн, 6-7 эртэй бол 3 хүн” цэрэгт татах хуультай байжээ. Энэ хуулийг монгол айл өрхөөс цэрэг татахдаа баримталж байжээ. Үүний зэрэгцээ хятад газар байсан Юань улсын цэргийн нөхөн хангалтыг цэргийн өрхөөс цэрэг татах аргаар явуулж байжээ. Цэргийн өрх гэдэг нь хятад газар нүүн очсон монгол айл өрх хийгээд эзлэн авсан Алтан улс, Сүн улсын буун өгсөн цэргийн ар гэр юм.

Цэргийн хүн алба хаах хуулийг гурван үеэрээ цэргийн алба хааж буй өрхийн хүмүүс сайн мэддэг байсан.

Юань улсын хуульд зайлшгүй “Өөрийн биеэр алба хаана”, “Зөрчин эсэргүүцэгчид ялтай” хэмээн заасан байдаг. Гэр орон нь ядуугийн улмаас оргон зайлсан тохиолдолд хариуцсан түшмэлийн алба нь зайлшгүй хянан нягтлах шаардлагатай ба хэрвээ хуурамчаар ядуу мэт дүр эсгэсэн бол хяналтын хэлтэс нэмэлт мөрдлөг явуулдаг байв.

Юань улсын үед цэргийн өрх, тамачи цэрэг, хятад цэрэг, нөхвөр цэргийн өрхийн бүртгэлийг тусгайлан хөтөлж, өрхийн хөрөнгө чинээ, хөдөлмөрийн чадвар, алба хаах боломжийг харгалзан цэрэг татах бодлого хэрэгжүүлж байв. Ялангуяа жинхэнэ болон нөхвөр цэргийн өрхийн тогтолцоо нь цэргийн албыг тасралтгүй үргэлжлүүлэх, цэргийн хүний хомсдолоос сэргийлэх зорилготой байжээ. Цэргийн алба нь удам дамжин үргэлжлэх шинжтэй байсан бөгөөд өрхийн эрэгтэй гишүүд, хүргэн, төрөл садны хүмүүс хүртэл цэргийн үүргийг залгамжлан биелүүлэхээр хуульчлагдсан нь төрөөс цэргийн өрхийн тогтвортой байдлыг онцгойлон анхаарч байсныг харуулдаг.

Юань улсын цэргийн хууль нь зөвхөн цэрэг татлага, цэргийн алба хаах асуудлыг зохицуулаад зогсохгүй цэргийн сахилга бат, цэргийн гэмт хэрэг, дайны үеийн журам, цэрэг-иргэний харилцаа зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарч байжээ.

Түлхүүр үгс: Юань улс, цэргийн албаны хууль, шагнал, шийтгэл, тэтгэмж, өрхийн бүртгэл

Оршил

Юань улсын цэргийн алба нь Монголын эзэнт гүрний уламжлалт цэргийн зохион байгуулалт дээр тулгуурлан хөгжсөн бөгөөд тухайн үеийн дэлхийн хамгийн хүчирхэг цэргийн тогтолцооны нэг байв. Юань улсын цэрэг нь монгол, хятад болон бусад олон угсаатны хүмүүсээс бүрдэж байсан бөгөөд төрийн эрх мэдлийг хамгаалах, байлдан дагууллыг үргэлжлүүлэх үндсэн үүрэгтэй байжээ.

Юань улсын үеийн цэргийн албаны хууль нь цэргийн хуульдаа багтаж, цэргийн албаны хууль нь бусад хуульдаа багтдаг байсан байна. 1264 оны 8 дугаар сард зохиосон “Шинэ эмхэтгэсэн хуулийн бичиг”, Жиюаний 8 дугаар он буюу 1271 оны 2 дугаар сард “Эрхэн зөвлөлийн мужаас өргөн боловсруулсан хуулийн бичиг, Жиюаны 28 дугаар он буюу 1291 оны 5 дугаар сард хэвлэн гаргасан “Жиюаны шинэ хууль”, Дадөгийн 4 дүгээр он буюу 1300 оны 3 дугаар сард хэвлэн гаргасан

“Дадөгийн хууль”, Инзун Жижигийн 3 дугаар он буюу 1323 оны 2 дугаар сард гарсан “Их Юаны нэвтэрхий хууль” зэрэг хуулинд цэргийн хууль ч мөн багтсан байдаг. Жишээлбэл: “Их Юаний нэвтэрхий хууль”-нд “цэргийн хамгаалалт” гэх нэг бүлэг байдаг бол Юань улсын дунд үед эмхэтгэн найруулсан “Ертөнцийг засах магад хууль”-нд “Цэргийн хууль” гэх бүлэг байдаг байна. Мөн Жиоаны 4 дүгээр он буюу 1338 оны 4 дүгээр сард дээд албаны эрхэн сайд Ажила Юань улсын нэвтэрхий хуулийг иш үндэс болгон зохиосон Жижэнь хуулийн бичигт цэргийн холбогдолтой 36 зүйл, шүүн таслах дүрмийн 71 зүйл, нийт 107 зүйл заалт нэмж орсон байна.

Судалгааны зорилго

Юань улсын цэргийн албаны тогтолцоо, түүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт, цэргийн өрхийн байгуулалт, цэрэг татлага, цэргийн сахилга бат болон цэргийн албаны хууль тогтоомжийн онцлогийг судлан, Монголын уламжлалт цэрэг-захиргааны тогтолцоо Юань улсын үед хэрхэн хөгжиж, төрийн тогтвортой байдлыг хангахад ямар үүрэг гүйцэтгэсэн болохыг тодруулахад оршино.

Судалгааны зорилт

- Юань улсын үеийн цэргийн албаны эрх зүйн үндэс, цэргийн хууль тогтоомжийн агуулгыг судлах.

- Цэргийн өрх, тамачи цэрэг, хятад цэрэг, нөхвөр цэргийн өрхийн зохион байгуулалт, бүртгэлийн тогтолцоог тодорхойлох.

- Цэрэг татлага, цэргийн алба хаах журам, нөхөн хангалтын тогтолцооны онцлогийг шинжлэх.

- Цэргийн алба хаагчид болон тэдний гэр бүлийг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн баталгааг судлах.

- Цэргийн сахилга бат, цэргийн гэмт хэрэг, түүнд оногдуулж байсан ял шийтгэлийн онцлогийг тодруулах.

Юань улс байгуулагдсаны дараа монголын олон овог аймгууд урьдын адилаар насанд хүрсэн эр хүн (15-70 нас) бүр эр цэрэг болдог хэвээр байв. Бусад үндэстний ардууд цэргийн албанд хүчээр явдаг байв. 1279 оноос өмнө тамачи цэрэг болон хятад цэргийн данс бүртгэлийг төгөлдөржүүлэх ажил үндсэндээ дуусав.

Юань улсын сударт “Цэргийн хуулиар өрхийн эр хүнийг арван таван наснаас дээш бол олон цөөнийг нь харгалзан цэрэг болгоно. Арван хүнийг аравт болгож, аравны дарга тавина. Морин дээр гарвал байлдан дайлахад бэлтгэн, мориноос буувал албан тариа тарьж, мал маллана. Балчир хүүхдийг багахан өсмөгц бүртгээд өсвөр эрийн цэрэг болгоно. Дундад орныг түвшитгэснээс хойш иргэнээс авсныг хятад цэрэг гэнэ. Эс бөгөөс баян үгээгүйг хөх, хөхөгчин өрх болгож, нэг хүн гаргасныг ганц өрхийн цэрэг гэнэ. Хоёр гурван өрх нийлж нэгэн хүн гаргавал жинхэнэ цэргийн өрх болно. Бусдыг нь нөхвөр цэрэг өрх болгоно” (Г.Сүхбаатар, Л.Жамсран 1968) хэмээн өгүүлжээ. Жинхэнэ цэргийн өрхийг мөн толгой цэргийн өрх гэж нэрлэж байжээ.

Тамачи цэргийн тухайд гэвэл, 1262 оны (Гуравдугаар он) 3 дугаар сард гарсан зарлигт: “Жэньдин, Чандэ, Синжоу, Минци, Дунпин, Дамин, Пинъян, Тайюань, Вэйхүй, Хуаймэн зэрэг газар өмнө нь Аньчар, Боуо, Сяонай, Хөхбуха, Бүрх баатар

зэрэг түшмэдийн харьяанд байсан тамачи морьт цэргүүдийг хөхөгчин туулай жил дансалж иргэн болгосон ба цэрэгт татагдсан хүмүүс ч байна (宋濂、王祎 1976). Энэ зарлиг нь Хубилай хаан суурин суусан эхний жилүүдэд монгол цэргийн зохион байгуулалт болон хятадын суурин хүн амын бүртгэлийг шинэчлэн журамлаж байсантай холбоотой гарсан. Мөн монголчууд хойд хятадыг эзэлсний дараа олон тамачи цэргийг суурьшуулсан. Тамачи цэргийн алба цэргийн бусад албыг бодвол харьцангуй хүнд учир олон жил алба хаасан цэргүүдээ чөлөөлж, жирийн амьдралд шилжүүлсэн бололтой. Энэ үед өөр бусад төрлийн харуул хамгаалалтын цэргүүдийг байгуулагдаж, тамачи цэргүүдийн гүйцэтгэх үүрэг багассан учир тоог нь цөөлсөн байж болно.

Юань улсын үед өрхийн бүртгэл нь ардын, цэргийн, өртөөний өрхийн гэх гурван төрөл байв. Ардын өрх гэдэгт тариачин өрхөөс гадна гар үйлдвэрлэл эрхлэгчид буюу дархан, мужаан, давс ширгээгчид, шашны болон бичиг номын хүмүүсийн өрх гэрийхэн хамаарагдаж байлаа. Өртөөний бошго түшмэлийг “Төрийн хэрэг захиран шийтгэх яам” болон “Цэргийн явдлын яам”-наас хавсран томилох ба өртөөний албыг засгийн газраас томилсон өртөөний өрх хариуцан залгуулж, өртөөнд хэрэглэх морь, үхэр, тэрэг, завь зэргээр хангаж, усчин агтчин нарт хариуцуулж, өртөөгөөр дамжин өнгөрч буй элчийг хоол хүнс, дэнгийн тос, түлээ түлш зэргээр хангадаг байв (罗琨、张永山 1998, 第371-372 页). Цэргийн өрх нь газар тариалан эрхлэх ба өрх бүр 4 чин (чин-талбайн хэмжих нэгж. Нэг чин нь зуун м²) газрын аму будааны татвараас чөлөөлөгдөж “Асран тэтгэх цэргийн өрхийн газар” гэж нэрлэгддэг байв. Монгол тамачи (монгол болон бусад үндэстний цэргээс бүрдэнэ) цэрэг болон хятад цэргийн өрх нь аурагийн зохион байгуулалтаар эмхлэн зохион байгуулагддаг байсан байна (中国大百科全书 1981, 第41 页). 1264 оны 2 дугаар сард зарлиг гарч, олон замын аурагыг орон нутгийн захиргаанд харьяалагддаг байсныг нь болиулж, шумиюаны мэдэлд захируулсугай хэмээжээ (宋濂、王祎 1976).

Цэргийн данс бүртгэлийг хятад цэргийн, тамачи цэргийн (монгол цэргийн) болон нөхвөр цэргийн өрхийн данс бүртгэл гэж 3 хувааж байв. Хятад цэргийн өрхийн бүртгэл явуулахдаа тухайн ардын өрхийн хөрөнгө болон хөдөлмөрлөх хүчний харилцан адилгүй байдлаас хамааран дээд, дунд, доод гэж гурав хуваан үүнийгээ дотор нь дахин 9 хэсэг болгон хуваадаг байсан байна. Үүнд:

- дээдийн дээд;
- дээдийн дунд;
- дээдийн доод;
- дундын дээд;
- дундын дунд;
- дундын доод;
- доодын дээд;
- доодын дунд;
- доодын доод.

Дээр өгүүлсэнчлэн айл өрхийн эрхэлж буй аж ахуй, баян ядуу, эрүүл, өвчтэй зэргийг харгалзан цэргийн албанд татах, чөлөөлөх эсвэл тариа тариулдаг байсан тухай Юань улсын сударт: “Арван нэгдүгээр сард Шандун, Хөнан-ий хил хязгаарын

дагуух жөү жяний иргэний өрхөөс сонгож цэрэг болгоод, байлдах дайтав болбоос хүчирхэг өрхийнхөн хил хамгаалж буй хятад цэргүүдийн хамтаар дайлмуй. Хүч чадал муутай айлуудыг оронд нь хил хязгаар хотыг хамгаалан сахих ба жич албан тариа тариулж, цэргийн хүнсэнд нэмэрлүүлэхээр шийдэв”, “Хэрэв ядуу дорой, өөрсдөө бэлтгэж чадахгүй хүн байвал тухайн мянгат дотроос “тулхуа”-д явах ёсгүй хүмүүс нийлж туслан, замд нь гаргана. Үүний улмаас бусад цэргүүдэд нэмэлт алба, татвар ногдуулахыг хориглоно”, “Манай замын цэрэг эдүгээ 40 жил өнгөрөх хооронд зарим нь үхжээ зарим нь оргожээ. Эргүй тул нөхөж чадахгүйн улмаас цэрэг цөөн тул тэнцэх нэгнийг нь сонгож, тэнцэхгүйг нь үлдээж, ядуу бөгөөд цэргийн албанд дайчлах хүнгүй өрхүүдийг албанаас чөлөөлж оронд нь иргэний албаны (民站) дундаас сонгон цэргийн албанд томилж өгнө үү” (宋濂、王禕 1976) гэх зэргээр бичжээ.

Дээрх бүгдийг харгалзан үзэлгүйгээр нийтийг хамарсан цэрэг татлага явуулах аваас ард иргэд эсэргүүцэн тэмцэж, үймээн самуун гардаг учир дээд байгууллагаас шийдвэр гаргахдаа нөхцөл байдлыг харгалзан үздэг байсан байна. Тухайлбал, Жыюаний хоёрдугаар оны наймдугаар сард, Шаансыгийн таван замын болон баруун шу (Сычуань нутгийг, ялангуяа Чэндүгийн тал хөндийг төв болгосон Баруун Шугийн бүсийг заана. “Баруун Шу” (Шишу) гэдэг нь эрт үед Сычуаний баруун хэсгийг нийтэд нь нэрлэдэг ерөнхий нэр байжээ. Харин “Сычуань” хэмээх нэр нь Умард Сүн улсын үеийн “Чуаньшягийн дөрвөн зам” буюу Ижоу зам, Личжоу зам, Зычжоу зам, Куйчжоу зам гэсэн дөрвөн захиргааны нэгжийн товчилсон нэрээс үүссэн юм.) –ийн 4 чуаний салбар төвлөн засах яамнаас мэдүүлсэн нь: “Шинэ сонгох 7000 цэргийг ардын өрхөөс гаргавал үймээн самуун үүснэ. Эдүгээ Гунчаньд хуучин цэрэг 3000, олон замын цэрэг 2000 байна. Үлдсэн 2000 хүнийг заавал иргэдээс татах шаардлагагүй, нөхцөл байдалд тохируулан нөхөн бүрдүүлж болно” хэмээснийг ёсоор болгожээ.

Юань улсын үеийн хаадын зарлиг, хууль цаазын баримтуудаас үзэхэд төрөөс цэргийн алба хаагчид болон тэдний ар гэрийнхтэй холбоотой аливаа асуудалд онцгой анхаарал хандуулж байжээ. 1260–1307 оны хооронд гарсан хууль, зарлигуудад дайнд оролцож буй цэргүүдийн ар гэрийг хамгаалах, тэдний амьжиргааг дордуулахгүй байх, албан тушаалтнуудын дарамт шахалт, хөрөнгө мөнгө завших явдлыг таслан зогсоохыг удаа дараа сануулсан байна. Мөн байлдаанд амь үрэгдсэн, өвчнөөр нас барсан цэргийн ар гэрт олгох тэтгэмжийг нэмэгдүүлэх, ядуу дорой өрхүүдэд тусгай халамж үзүүлэх, өмсөх хувцас, идэх хүнсээр хангах зэрэг арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, Юань улсын хууль цаазын бичгийн хоёрдугаар бүлгийн “Цэргийн хүнийг тохинуулах” зүйлд “Их цэргийн жил бүрийн дайнд давшин орогсодод илэрхий зовлон байх ба хоцрон суугчдад зүглэлийн зүдгүүр байх бөгөөд ялангуяа асралыг мэдэхгүй цэргийг захирсан тэргүүлэгч толгойлогч түшмэл, цалин хүнсийг догшрон авах учирт, өмнө цэрэгт явж бүхүй түүний гэрийн хүмүүсийг самууруулж, амаргүй болгоход хүрүүлжээ би. Үүнийг туйлаар нигүүлсэх болой. Үүнээс хойш олон замын цэргийг захирсан тэргүүлэгч түшмэл нарыг дахиж тийм явдал гарахыг цаазалмуй. Аливаа хэрэгт нэгээр шинэтгэмүй. Бүү хуучин гэмээ дагаж явуул. Хэрэв өмнө бүхүй цэргийн хүн гавьяа зүтгэл байгуулсан байваас дүрмийг дагаж, шагнах хуулиар элбэг зузаанаар тохинуулан, амгалангаар тэжээгтүн”, “Дарангуйлан суух ба дайнд явсан цэрэг

хүмүүс удаанаар зовлон зүдгүүрийг эдэлжээ. Цэргийг хамаарсан түшмэл, одоо оолу (奥魯 ào lǔ)-г захирсан түшмэд цэргийн хүнийг илбэн тэжээхэд, оолу-г хамаарсан түшмэл бүү омтгойлон, өмсөх идэхийн зүйлийг тэсгэгтүн. Хуульд өгвөөс зохихыг цаг улирлыг дагаж өгсүгэй. Бүү хоорондод завишгтун. Цэргийн хүний байлдааны талбайд үхсэн ба өвчинд нэрвэгдэж үхсэнийг нэн хөөрхийлөн нигүүлсвээс зохих тул, хуульд эрхгүй нэг жил тэтгэлэг өгөх ёстойг хоёр жил болгож, хагас жил өгөх ёстойг нэг жил болгосугай. Ядуу доройд хүчээр амьдарч чадахгүйг Шү ми юань яамнаас үлэмжээр тэтгэхийг тогтоомуй”, “Жинхэнэ цэргийн өртөөний өрх ядуу баялаг, чийрэг буурай нь тэгшгүй тул, улсад тогтоосон хуулиас гадна, тус тусд нэг бүхэл бөс даавуугаар шагнасугай. Харьят газрын ахалсан түшмэл үргэлж үзэн харж, дагаж явуулах нь туйлд хүргэж эс чадсаныг Байцаан сурвалжлах хэлтсээс байцааж залхаатугай”, “Дайнд бие барсан цэргийн өрхөд хууль ёсоор хэтэрхий тэтгэмж өгөхөөс гадна, хэрэв үнэхээр биеийн хүч дорой бөгөөд амьдрал ядуу, хүчээр амьдарч чадахгүй хүн байваас, албан газраас идэх өмсөх зүйлийг өгч асран тэжээтүгэй”, “Хол дайнд явж бие барсан цэргийн хүнийг ер тогтоосон туйлаас илүү нэг жил тэтгэмжийг өгсүгэй”, “Умар этгээдийн цэргийн хүн жил бүр дайнд явж, зовлон зүдгүүр ихтэй тул, Шү ми юань яамны тогтоолыг дагаж, гавьяатайд шагнаан дэвшүүлж, ядуу үгээгүйд өглөг өгсүгэй. Байлдаанд алагдсан ба дайны талбай үхсэн хүний гэрт тэтгэмж өгсүгэй. Түүнээс гадна, цэргийн хүний өвчинд нэрвэгдэгсдийг өөр зүйлээр тогтоож, цөм тусгайлан үлэмж асралыг нэмүү өгөх ба мөн цэрэг захирсан түшмэл, оолу түшмэл цэргийн албан түшмэд бүү ёс бусчлан тэсгэн самууруулагтун” (Б.Алтанбагана 2024, 44-45) гэх зэрэг заалтууд орсон байна.

Эрчүүдийг цэргийн албанд татахдаа “Өрх бүр 2-3 эртэй бол нэг хүн, 4-5 эртэй бол 2 хүн, 6-7 эртэй бол 3 хүн” цэрэгт татах хуультай байжээ. Энэ хуулийг монгол айл өрхөөс цэрэг татахдаа баримталж байжээ. Үүний зэрэгцээ хятад газар байсан Юань улсын цэргийн нөхөн хангалтыг цэргийн өрхөөс цэрэг татах аргаар явуулж байжээ. Цэргийн өрх гэдэг нь хятад газар нүүн очсон монгол айл өрх хийгээд эзлэн авсан Алтан улс, Сүн улсын буун өгсөн цэргийн ар гэр юм (Б.Даваасүрэн, Б.Гомбосүрэн нар 1996, 296). Мөнгөн тусламж үзүүлж буй өрхийг нөхвөрлөх өрх гэнэ.

Жинхэнэ болон нөхвөрлөх өрхийг засгийн газар тэгш эрхтэйгээр тогтоосон бөгөөд үүнийг өөрчилж болохгүй. Хэрвээ цэргийн жинхэнэ өрхөөс алба хаах эр хүнгүй бол цэргийн алба хааж болохоор нөхвөрлөх өрхөөс хүн авч алба хаалгах ба түүний оронд цэргийн жинхэнэ өрх нь мөнгөн тусламж үзүүлдэг байв. Алба хааж буй цэрэг дайнд болон бослого дарахаар явах үедээ оргож зугтвал өөрийнх нь ах дүү нарын хэн нэгийг нь хүчээр оронд нь алба хаалгадаг байжээ. Цэрэг нь аян дайнд амь үрэгдвэл тухайн өрхөөс нэг жил цэрэгт хүн элсэхийг хойшлуулдаг ба хэрэв өвчнөөр үхвэл хагас жил цэргийн албыг хойшлуулдаг байжээ (吴秀永 1994, 第128 页). Мөн дайнд оролцсон цэрэг дараагийн дайн байлдаанд оролцохгүй нэг буюу түүнээс дээш жилээр өнждөг байсан байна.

Цэргийн хүн алба хаах хуулийг гурван үеэрээ цэргийн алба хааж буй өрхийн хүмүүс сайн мэддэг байсан. Юань улсын хуульд зайлшгүй “Өөрийн биеэр алба хаана”, “Зөрчин эсэргүүцэгчид ялтай” (黄时鉴 1987) хэмээн заасан байдаг. Гэр орон нь ядуугийн улмаас оргон зайлсан тохиолдолд хариуцсан түшмэлийн алба нь

зайлшгүй хянан нягтлах шаардлагатай ба хэрвээ хуурамчаар ядуу мэт дүр эсгэсэн бол хяналтын хэлтэс нэмэлт мөрдлөг явуулна. Цэргийн өрх ядуу татуугийн улмаас тэтгэлэгт хамрагдсан (хэдэн жил цэргийн албанаас чөлөөлөгдсөн) хэдий ч цэргийн албанаас зайлсхийвэл 80 занчуулж цэрэг болно. Нуун далдалсан хүн зэрэг буурна, хоёр хөрш мэдсээр байж түрүүлэн илчлээгүй бол мөн нуун далдалсан ял оноож хоёр зэрэг бууруулна. Сахин хамгаалах цэрэг зугтвал 107 удаа занчиж, дахин зугтвал үхэх ялтай. Хэрвээ дайлаар явах үед оргон зугтвал олны өмнө цаазална. Бүх цэргийн ноёд түшмэд хээл хахууль авч дураараа загнаж цэргийн хүнийг төлөөлсөн болон зугтаалгасан тохиолдолд хөнгөн нь тушаал буулгах, хүнд нь нэрийг нь хасах шийтгэлтэй байв (吴秀永 1994, 第138 页). Цэргийн өрхийн тогтвортой байдлыг хангахын тулд Юань улсын засгаас эрэгтэй хүүхэдгүй айлын хүргэн болон төрөл садны хүү, ач нар тухайн айлын өрхийн аж ахуйг залгамжлан авч явж байгаа бол биеэр цэргийн алба хаах буюу цэргийн хэрэгт хавсран туслах үүрэг хүлээнэ гэж тогтоосон байна.

Шинээр хавсарсан цэрэг нас барвал бэлэвсэн эхнэрийн гэрт “Түшмэл хүн өрх гэр болоход нь хавсран тусална” гэж заажээ. “Эмэгтэй хүүхэдгүй цэргийн өрх”-д эхнэр болж очсон бүсгүй эрэгтэй хүүхэд төрүүлбэл тэр нь цаашид цэргийн өрхийг залгамжлан явна. Түүнээс гадна цэргийн өрхөд үзүүлэх татварын хөнгөлөлт, цэргийн өрхийн амралтын хугацаа зэргийг тодорхой тогтоосон байв.

Их монгол улсын үед цэргүүд их аянд мордохдоо дураар алж, тонож дээрэмдэхийг хатуу хориглодог байв. Морьт цэрэг заасан газраас өөр газарт дураар хүн хороовол эд хөрөнгө, эхнэр хүүхэд, морь малыг нь ганцыг ч үлдээлгүй юу ч үгүй болтол нь хураан авдаг байв. Тал нутгийн энэхүү хууль Хубилай хааны үед илүү боловсронгуй болсон байна. Хятад газрыг илбэн тохинуулах болон бүх улсыг нэгтгэсний дараа Юань улсын ноёрхогчид булааж тонон дээрэмдэхийг хориглосон шинэ хууль гаргасан байна. Цэргүүд дайлаар явахдаа “Жирийн ардыг булаан дээрэмдэх”, “Зарлиг тушаалгүй морьт цэрэг, элчин сайд зэрэг хүмүүс хот суурин газар орж энгийн номхон иргэдийг түйвээн сандаргах” (吴秀永 1994, 第139 页) -ыг хуулиар хориглосон байсан ба олзлогдон булаагдсан хүүхэд, хөгшдийг бүгдийг нь тосгонд нь буцаагаагүй болон дээрэм тонуул хийсэн этгээдийг цэргийн хуулиар шийдвэрлэх заалттай байв. Жишээлбэл: Юань улсын жанжин Алихай цэргээ удирдан Тан жоуг эзэлсний дараа дураар алж хядахыг хатуу хориглож байжээ. Ачу жанжин Хуйадунд довтлох үед нэг цэргийн дарга ардуудаас хоёр морь булаан авсан учир олны өмнө цаазлуулжээ. Сүн улсын хаан бууж өгснийхөө дараа Юань улсын цэрэг Лин Ань хотоос хойш 15 ли газарт байрласан ба Баян жанжин цэргүүдийг хот руу орохыг хориглож, зөрчсөн этгээдийг хуулийн дагуу шийтгэнэ хэмээж байв. Юань улсын цэргийн хуулиар “Газар газрын сахин хамгаалах цэргүүд байрласан газартаа өөрийн хуаранг байгуулах, дайн байлдаангүй үед энгийн номхон иргэдийн гэрт дайран орох, хоол хүнс, эд хөрөнгийг нь булаан дээрэмдэх” (吴秀永 1994, 第139 页)-ийг хориглосон байжээ. Цэргүүд газар тариалан эрхлэх болон дайлаар мордох үед засгаас бүх хоол хүнсийг нь хангадаг байсан учир ард иргэдээс булаах шаардлагагүй байсан байна. Энэ тухай Юань улсын сударт: “Алс хол газарт удаан хугацаагаар суух тариалангийн цэргийн хуаран, түр зуур дайран өнгөрөгсдийн хоол хүнс болон нийт цэргийн агтын тэжээлийг түшмэл олгоно. Тариачдад саад тотгор учруулах, түйвээх, аялагч, зочдыг саатуулан зогсоохыг хориглоно” (罗琨,

张永山 1998, 第348页) хэмээн бичжээ.

Юань улс мөн монголчуудын уламжлалыг хадгалж байсан учир байлдааны хатуу чанд сахилга баттай байсан юм. Дайлаар мордох үед сахилга бат алдах, зарлигийг зөрчих, тогтоосон хугацаанаас хожимдох зэрэгт тухайн нөхцөл байдлаас шалтгаалан зохих ял шийтгэлийг оноодог байв. Цэргийн сахилга батын талаар Юань улсын сударт: “Байлдааны журмыг зөрчин ухарсан хүн үхэх ялтай”, “Цэргийн түшмэл албаа орхих, тариалангийн цэрэг хуарангаа орхих, явган цэрэг анги нэгтгэлээ орхих зэрэг нь бүгд ялтай. Байлдаан болохоос өмнө зугтвал үхэх ялтай”, “Цэргийн хүн дээрэм, хулгай хийгээд баригдах, онцгой чухал цэгийн харуулын байрыг орхиж явах, дуут тусламж өгөөгүй, хугацаа хоцрох, дарга байлдагчаа хороох, дайсныг үтэр түргэн хөөлгүй орхих зэрэг нь үхэх ялтай хэрэв өршөөл үзүүлэх бол асууж ярилгүй тушаалаас нь шууд буулгана”, “Нийт морьт цэргүүд дайран довтлохдоо харц ардыг олзлох, булаан дээрэмдэх, санаатай хүн ардыг худалдаж авах, болон амиа хорлох, өвчнөөр үхэгсдийн хүүрийг замд хаяж гээх зэргийг хатуу хориглоно” (罗琨, 张永山 1998, 第348页) хэмээн бичжээ.

Ийнхүү Юань улсын эхэн үед цэргийн сахилга бат хатуу чанга байсан хэдий ч дунд болон хожуу үед цэргийн сахилга бат нилээд суларч цэрэг энгийн ардын хоорондох олзлон булаах болон цэргийн хүн хулгайд холбогдох асуудлыг зогсоож чадахгүйд хүрсэн байна. 1338 онд гарсан Жиженъ хуулийн бичгийн шүүн таслах дүрмийн нэгдүгээр бүлгийн “Ордонд дур зоргоор орж гарах” хэмээх нэгдүгээр зүйлд тэмдэглэснээр Жяньнаны “Бууж өгсөн нэгэн өрх айл” цэргийн хүнд мөнгөө булаалган олзлогдоод Шанжоуд хүрсэн ба хожим нь нийслэлд хүрч ордонд нууцаар орж хэрэг явдлаа ярьсан тухай бичсэн байна. Мөн хуулийн 7 дугаар бүлгийн 215 дугаар зүйлд эзэн хаан цагаан сарын баяр тэмдэглэж байх үеэр ууланд малаа хариулж явсан Юннаны Шижоугийн ард Ван Шүннан цэргийнхэнд олзлогдоод харуул хийж байгаад зугтсан байна. Энэ мэт шийдвэрлэвэл зохих зөрчилтэй асуудал ихээр гарах болсон байна. Дээрх мэт зөрчлийг хэрхэн шийдвэрлэх тухай буюу цэргийн ноён цэргээ удирдан булаан олзолсон хэргийг шийдвэрлэх тухай шүүн таслах дүрмийн гуравдугаар бүлэг 93,94 –р зүйлд заасан байна.

Дүгнэлт. Юань улсын цэргийн албаны тогтолцоо нь эртний монголын төрт улсууд болон Их Монгол улсын үеэс уламжлагдан ирсэн аравтын тогтолцоонд суурилсан төр, цэргийн зохион байгуулалт, нийтээр цэрэглэх зарчим, цэргийн хатуу сахилга бат болон Хятадын суурин иргэншлийн төрийн захиргаа, хүн амын бүртгэл, татварын тогтолцоотой уялдуулан хөгжүүлснээрээ онцлог байв. Энэхүү тогтолцооны үндэс нь цэргийн өрхийн байгуулалтад тулгуурлаж байсан бөгөөд цэргийн албыг хувь хүний бус өрх гэрийн үүрэг болгон хуульчилснаар улсын цэргийн нөөц хүчийг тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлжээ.

Юань улсын үед цэргийн өрх, тамачи цэрэг, хятад цэрэг, нөхвөр цэргийн өрхийн бүртгэлийг тусгайлан хөтөлж, өрхийн хөрөнгө чинээ, хөдөлмөрийн чадвар, алба хаах боломжийг харгалзан цэрэг татах бодлого хэрэгжүүлж байв. Ялангуяа жинхэнэ болон нөхвөр цэргийн өрхийн тогтолцоо нь цэргийн албыг тасралтгүй үргэлжлүүлэх, цэргийн хүний хомсдолоос сэргийлэх зорилготой байжээ. Цэргийн алба нь удам дамжин үргэлжлэх шинжтэй байсан бөгөөд өрхийн эрэгтэй гишүүд, хүргэн, төрөл садны хүмүүс хүртэл цэргийн үүргийг залгамжлан биелүүлэхээр хуульчлагдсан нь төрөөс цэргийн өрхийн тогтвортой байдлыг онцгойлон анхаарч

байсныг харуулдаг.

Юань улсын цэргийн хууль нь зөвхөн цэрэг татлага, цэргийн алба хаах асуудлыг зохицуулаад зогсохгүй цэргийн сахилга бат, цэргийн гэмт хэрэг, дайны үеийн журам зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарч байжээ. Тухайлбал, байлдааны үед ухрах, оргон зайлах, тушаал зөрчих, харуул хамгаалалтын үүргээс татгалзах зэрэг үйлдлийг хүнд гэмт хэрэгт тооцож, үхэх ял хүртэл оноодог байсан нь Монголын цэргийн уламжлалт сахилгын зарчим Юань улсын эрх зүйн тогтолцоонд хэвээр хадгалагдсаныг харуулж байна.

Ийнхүү Юань улсын цэргийн албаны тогтолцоо нь Хүннүгийн үеэс уламжлагдан Их Монгол улсын Монголын цэрэг-захиргааны уламжлалыг хадгалан хөгжүүлж, олон үндэстэн бүхий өргөн уудам эзэнт гүрнийг удирдан захирах институцийн үндсийг бүрдүүлсэн байна. Цэргийн өрхийн байгуулалт, тамачи болон хятад цэргийн бүртгэлийн тогтолцоо, нөхвөр цэргийн зохицуулалт, хатуу сахилга бат бүхий цэргийн хууль зэрэг нь Юань улсын төрийн тогтвортой байдлыг хангах чухал тулгуур болсон бөгөөд тухайн үеийн цэрэг-захиргааны тогтолцооны хөгжлийг судлахад үнэтэй эх сурвалжийн ач холбогдолтой юм.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Б.Алтанбагана. 2024. *(Юань улсын хууль цаазын бичиг. (I-X))*. Монгол бичгээс шинэ үсэгт хөрвүүлэн хятад хэвлэлтэй харгуулж, хэлхээс үйлдсэн: С.Амарбаяр, Б.Нацагдорж, Г.Одбаяр, Н.Хатанбаатар. Улаанбаатар: “Удам соёл” ХХК.
2. Г.Сүхбаатар, Л.Жамсран. 1968. *БНМАУ-ын түүхийн дээж бичиг*. Улаанбаатар.
3. 1996.
4. Б.Даваасүрэн, Б.Гомбосүрэн. 1996. *Монгол цэргийн түүхийн товчоо. Тэргүүн дэвтэр*. Улаанбаатар.
5. 中国大百科全书. 1981. 北京.: 中国大百科全书出版社.
6. 吴秀永. 1994. 中国元代军事史. 北京: 人民出版社.
7. 宋濂、王祿. 1976. 元史. 卷九十八, 志第四十六. 北京: 中华书局.
8. 罗琨, 张永山. 1998. 中国军事通史第十四卷. 北京: 军事科学出版社.
9. 黄时鉴. 1987. 大元通制 考辨. 中国社会科学. 第2 期. 北京.